ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2019.12.23 Улаанбаатар хот

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| **А. Үйл ажиллагааны ил тод байдал** | | | |
| 1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | **ТЗУГ**:<br>Яамны цаг үеийн үйл явдлын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл түгээх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>Стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлж байгаа ажлын талаар болон Сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын шуурхай зөвлөгөөнөөр яамны газар, хэлтсүүдэд үүрэг болгосон материалыг цахим хуудсанд тогтмол байршуулж байна.<br>Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, УИХ-ын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Сайдын тушаал, дүрэм, журам, заавар зэрэг нийт 21 төрлийн хууль, эрх зүйн актыг байршуулсан. Дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 248 мэдээллийг байршуулсан. Үүнд:<br>• Яамны үйл ажиллагааны зорилт, бүтэц зохион байгуулалтын чиглэлээр 6 мэдээлэл,<br>• Мэдээлэл цэсний өргөдөл гомдол, шүүхийн шатанд буй хэргийн талаар 5 мэдээлэл,<br>• Салбарын шагнал цэсэнд 1,<br>• Хүний нөөцийн стратеги цэсэнд 3,<br>• Ажлын байр цэсэнд 4,<br>• Албан хаагчдын жагсаалт цэсэнд 2,<br>• Албан хаагчдын ёс зүй цэсэнд 1<br>• Байгууллагын соёл, дэг журам цэсэнд 1,<br>• Үйл ажиллагааны төлөвлөгөө цэсэнд 2,<br>• Үйл ажиллагааны тайлан цэсэнд 8,<br>• Хамтын ажиллагаа цэсэнд 2,<br>• Авто замын чиглэлээр 23 мэдээлэл,<br>• Автотээврийн чиглэлээр 15 мэдээлэл,<br>• Төмөр замын чиглэлээр 23 мэдээлэл,<br>• Агаарын тээврийн чиглэлээр 8 мэдээлэл<br>• Далай, усан замын тээврийн чиглэлээр 5 мэдээлэл,<br>• Уулзалт, зөвлөгөөн, айлчлалтай холбоотой 34 мэдээлэл ,<br>• Яамнаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чиглэлээр 13 мэдээлэл,<br>• Бусад цаг үеийн үйл явдалтай холбоотой 88 мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлсэн байна.<br>Яамны үйл ажиллагааны тайланг сар бүрээр тайлан хэлбэрээр цахим хуудасны үйл ажиллгааны тайлан хэсэгт оруулсан. | ТЗУГ-100 %<br>БТГ-100 %<br>ХШҮДАГ-100 %<br>**Дундаж үнэлгээ 100 %** |

| | | | |
|---|---|---|---|
| | | **<u>БТГ:</u>**<br>• Стандарт норм цэсэнд 2 мэдээлэл<br>• Үйл ажиллагааны тайлан цэсэнд 1 мэдээлэл<br>Төсөл хөтөлбөр цэсэнд 3 мэдээлэл, нийт 6 мэдээлэл,<br><br>***"<u>Худалдан авах ажиллагааны ил тод</u>"*** буланд:<br>• Тендерийн урилга- 8<br>• ЗТХЯ-ы 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө<br><br>**<u>"ИЛ ТОД БАЙДАЛ"</u>** үндсэн цэсийн ***"Үйл ажиллагааны ил тод байдал"*** булангийн ***"Тайлан, төлөвлөгөө"*** хэсэгт:<br>• БТГ-аас Яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө,<br>• ТЗДТБХЗГ-аас 2019 оны 1 болон 2-р улиралд хийсэн ажлын тайлан,<br>• ТЗУГ-аас яамны үйл ажиллагааны сар бүрийн тайланг байршуулсан.<br><br>**<u>ХШҮДАГ:</u>**<br>***"Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит"*** булангийн "Хяналт-шинжилгээний тайлан" хэсэгт:<br>• Засгийн газрын хуралдаанаар 2019 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга<br>• Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан<br>• Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан<br>• Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан<br>• Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад 2017 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан /ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ<br>• Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан байршуулсан.<br>• Яамны мэдээллийн самбарт 2018 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг байршуулж мэдээлсэн.<br><br>**<u>"Зам, тээврийн хяналт</u>**" хэсэгт:<br>• ЗТХЯ, МХЕГ-ын 2019 онд хамтран ажиллах төлөвлөгөө байршуулсан,<br>• ЗТХЯ, МХЕГ-ын 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан<br>• Автотээврийн хяналтын чиглэлээр АТҮТ ТӨҮГ-тай 2018 онд хамтран ажиллах төлөвлөгөө байршуулсан,<br><br>**<u>"Шилэн дансны хяналт"</u>** буланд**:**<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний ТӨҮГ-уудын 2018 оны шилэн дансны тоон тайлан /2019.01.27/ | |

| | | | |
|---|---|---|---|
| | | • ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны 2018 оны мэдээллийн байдалд хийсэн аудитын тайлан<br><br>**<u>“Шилэн данс”</u>** цонхонд:<br>Төсөв/гүйцэтгэл хэсэгт дараах мэдээллийг хуваарийн дагуу байрлуулсан. Үүнд:<br>• Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт ( 1- 11-р сар, 1,2,3-р улирлын мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан)<br>• Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (1- 11-р  сарын мэдээллийг байршуулсан)<br>• Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Яамны урсгал дансны 1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан)<br>• Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (1- 11-р сарын мэдээллийг байршуулсан) | |
| 2 | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;<br>ТЗУГ | **<u>ТЗУГ</u>**<br>• Зам, тээврийн хөгжлийн сайдын туслах, Төрийн нарийн бичгийн даргын туслах, болон бичиг хэргийн эрхлэгчтэй холбоо барих мэдээллийг мэдээллийн самбарт харин өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн  болон угтах үйлчилгээний ажилтаны утас болон мэйл хаяг, ажлын цагийн хуваарийг байгууллагын цахим хуудсанд **“Санал хүсэлт”** буланд байршуулсан.  Мэдээллийг цаасан хэлбэрээр болон электрон самбарт цахимаар байршууллаа.<br>• Яамны цахим хуудасны “Ил тод байдал” үндсэн цэсний “**Хүний нөөцийн ил тод байдал”** буланд Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын нэрс, харилцах утас, цахим шуудангийн мэдээллийг 2019.12.10-ны байдлаар шинэчилж байршуулсан.<br>• Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой ажилд баримтлах хууль, эрх зүйн заалтуудыг мэдээлсэн.<br>• Яамны цахим хуудас mrtd.gov.mn цахим хуудсаар нийт 156 майл ирснээс өргөдөл гомдол 13, санал мэдээлэл 40 , урилга 19,  хамтран ажиллах тухай 56, шагналын тухай 28ш ирснийг холбогдох мэргэжилтнүүдэд хуваарилж шийдвэрлүүллээ. Мөн шинэчилсэн цахим хуудсанд Онлайн туслахын “tawk.to” буланг ажлын цагаар ажиллуулж байгаа бөгөөд энэ буланд 4 дүгээр улирлын байдлаар 1250 гаруй хүн хандаж мэдээлэл авсан бол офлайн горимд 186 хүн захидал үлдээснийг холбогдох хүмүүст нь хүргэж ажилласан байна.<br>Угтах үйлчилгээний ажилтаны мэдээлэл болон ажиллах журмыг  “Иргэдийн санал хүсэлт хүлээн авах” буланд байршуулсан. Яамны Мэдээллийн самбарт 15 удаа мэдээ шинэчилсэн бөгөөд угтах үйлчилгээний хэсэгт электрон самбар байршуулж цаасан самбарыг шинэчиллээ. | ТЗУГ-100 % |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Яамны цахим хуудасны **“Төрийн үйлчилгээ”** буланд мэдээлэл шинэчилсэн байдал:<br><br>**<u>“Авто зам”</u>** цэсд:<br>• Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам,<br>• Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам,<br>• Тусгай зориулалтын авто зам барих, ашиглах журмуудыг тус тус байршуулсан.<br>• Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг 2019.12.12-ны өдрийн байдлаар шинэчлэн байршуулсан<br>• Авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг 2019.12.12-ны өдрийн байдлаар шинэчлэн байршуулсан.<br>• Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй компаниудын жагсаалтыг 2019.12.12-ны өдрийн байдлаар шинэчлэн байршуулсан.<br><br>**<u>“Дүрэм, журам”</u>** цэсд:<br>• Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 312 дугаар тогтоолоор батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх журам”-ыг байршуулсан.<br>• Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Тусгай зориулалтын авто замын чиглэл батлах тухай” 272 дугаар тушаалыг байршуулсан.<br><br>**“Авто тээвэр”** цэсд:<br>• Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг 2019.04.18-ны өдрийн байдлаар шинэчилсэн.<br>• Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг 2019.01.18-ны өдрийн байдлаар шинэчилсэн.<br>• Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтыг 2019.12.10-ны байдлаар шинэчилсэн.<br>• Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтыг 2019.12.09-ны байдлаар шинэчилсэн.<br><br>**<u>БТГ:</u>**<br>Үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм журам, тайлан мэдээг mrtd.gov.mn вэб хуудсанд байршуулсан. Үүнд:<br>• 2019 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын худалдан авах ажиллагааны тайлан<br>• 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө<br>• Төмөр замын салбарын хэмжээнд 2019 онд батлагдсан стандартуудыг Ган зам сонинд хэвлэн нийтлүүлж мэдээллийг түгээсэн. | АЗБХЗГ-100 %<br>АТБХЗГ-100 %<br>БТГ-100 %<br>ТЗДТБХЗГ-100%<br>АТБХЗХ -100 %<br>**Дундаж үнэлгээ 100 %** |

| | | | |
|---|---|---|---|
| | | • Зам, тээврийн салбарын инновацын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг яамны дотоод сүлжээнд 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдөр тавьсан.<br><br>**<u>"Шилэн данс"</u>** цонхонд**:**<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг зохих журмын дагуу байршлуулсан<br>• Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (1-11-р сарын мэдээллийг байршуулсан<br><br>**<u>"Төмөр зам, далайн тээвэр"</u>** цэсд:<br>1 дүгээр улиралд 6, 2 дугаар улиралд 14, 3 дугаар улиралд 5 мэдээлэл байршуулсан. **Үүнд:**<br>• Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүртгэл;<br>• Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл шинээр олгосон хуулийн этгээдийн бүртгэл;<br>• Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргахад шаардагдаж буй Техник, эдийн засгийн урьдчилсан үндэслэл боловсруулах аргачлал;<br>• Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объектын гэрчилгээ шинээр олгосон, сунгасан, хүчингүй болгосон хуулийн этгээдүүдийн бүртгэл;<br>• Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим үйл ажиллагааны гэрчилгээ шинээр олгосон, сунгасан, хүчингүй болгосон хуулийн этгээдүүдийн бүртгэл;<br>• Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект үйл ажиллагааны гэрчилгээг хүчингүй болгосон хуулийн этгээдүүдийн бүртгэл;<br>• Төмөр замын аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээ шинээр хүсэх сунгуулах үед бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт;<br>• Тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахад анхаарах зүйл гэх мэт усан замын тээврийн тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн мэдээлэл болно.<br>Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай зарим объектын үйл ажиллагааны гэрчилгээ хүчингүй болсон, шинээр авсан этгээдийн бүртгэл /2019.12.11/;<br>Төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын 5 төрлийн жагсаалтыг /2019.12.10/ тус тус шинэчилсэн.<br><br>**<u>"Агаарын тээвэр"</u>** цэсд:<br>• Иргэний нисэхийн багц дүрмийн дагуу олгодог 3 төрлийн тусгай зөвшөөрлийг олгоход тавигдах шаардлагуудын талаарх мэдээлэл, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсанд 2019.03.23-ний өдөр шинэчилсэн. Тус хэлтэс тусгай зөвшөөрөл болон гэрчилгээжүүлэлт олгох асуудлыг хариуцдаггүй ИНЕГ бие даан хариуцдаг тул уг мэдээллийг байнга шинэчлэх боломжгүй юм. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | **<u>Салбарын шагнал буланд:</u>**<br>• Салбарын шагналд тодорхойлоход шаардлагатай эрх зүйн актууд, бүрдүүлэх баримт бичиг зэрэг мэдээллүүдийг шинэчилсэн.<br>Яамны газар, хэлтсээс үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг ашиглах аппликейшн хийгдэж байна. Аппликейшнийг 2019 оны дөрөвдүгээр улирлаас ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд ингэснээр шинээр суурилуулсан цахим мэдээллийн самбараас, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг ашиглах боломжтой болно. | |
| 4 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;<br>Яамны газар, хэлтэс | **<u>ТЗУГ:</u>**<br>Зам, тээврийн салбарын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа эрх зүйн актын жагсаалтыг 2019 оны 12 дугээр сарын байдлаар гаргаж, яамны вэб сайтад байршуулсан. Шинээр батлагдсан салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр нь "**ЭРХ ЗҮЙ**" буланд байршуулж байна.<br>2019 оны дөрөвдүгээр улирлын байдлаар байршуулсан нийт мэдээ:<br>• Засгийн газрын 19 тогтоол<br>• Ерөнхий сайдын 15 захирамж<br>• ЗГ-ын хуралдааны 18 тэмдэглэл<br>• Сайдын 14 тушаал<br>• Дүрэм журам 10<br>• Хууль журмын төсөл-5<br>Шинээр батлагдсан салбарын чиглэлээрх хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр нь байршуулж байгаа бөгөөд нийт 39 дүрэм журам байршуулаад байна.<br>**<u>БТГ:</u>**<br>Зам, тээврийн салбарын стандартчилал, тохирлын үнэлгээ, норм нормативын тогтолцоог боловсронгуй болгох хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж яамны вэб сайтад тавиад байна. Уг хөтөлбөрийн төсөлд цахимаар 30 хоногийн турш буюу 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийг хүртэл санал авч нэгтгэн боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 161 дүгээр тушаалаар батлуулсан. Уг хөтөлбөрийг http://mrtd.gov.mn/i/1975 -д тавьсан болно.<br>Зам, тээврийн салбарын стандартчиллын техникийн хороодын 2019-2020 оны стандарртчиллын ажлын хөтөлбөр-төлөвлөгөө СХЗГ-ын даргын 2019 оны А/38 дугаар тушаалаар батлагдсныг тус яамны Вэб сайтад http://mrtd.gov.mn/i/1886 -д 2019 оны 4 дүгээр сарын 08-нд байршуулсан.<br>Цөмийн энергийн комиссын ажлын албанаас ирүүлсэн "Цацрагийн идэвхт материалыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны дүрмийн төсөлд санал авахаар 2019 оны 4 дүгээр сарын 10-нд яамны дотоод сүлжээнд байршуулсан.<br>**<u>АЗБХЗГ:</u>**<br>• Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам,<br>• Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам,<br>• Тусгай зориулалтын авто зам барих, ашиглах журмуудыг тус тус байршуулсан.<br><br>**<u>ТЗДТБХЗГ:</u>**<br>Төмөр замын тээврийн салбарын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа эрх зүйн актын жагсаалтыг 2019 оны 01 дүгээр улирлын шинэчилж батлагдсан Төмөр замын тээврийн 16 нийтлэг багц дүрэм, | ТЗУГ-100 %<br>БТГ-100 %<br>АЗБХЗГ-100 %<br>АТБХЗГ-100 %<br>ТЗДТБХЗГ-100%<br>ХШҮДАГ-100 %<br>АТБХЗХ-100 %<br>**Дундаж үнэлгээ 100 %** |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2 дугаар улиралд “Төмөр замын вагоны хос дугуйн засвар, ашиглалтын заавар”-ийг, 3 дугаар улиралд “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ыг, 4 дүгээр улиралд “ Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам”-ыг “**ЭРХ ЗҮЙ**” буланд байршуулсан.<br>**<u>АТБХЗГ:</u>**<br>• Замын хөдөлгөөний байдлын үндэсний зөвлөлийн хуралдаанаас гаргасан зөвлөмжийг 2019.11.12-нд байршуулсан.<br>**<u>ХШҮДАГ:</u>**<br>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг Яамнаас шинээр суурилуулсан цахим мэдээллийн самбарт байршуулаагүй байна. | |
| 5 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;<br>Яамны газар, хэлтэс | 2019 оны дөрөвдүгээр улиралд Зам, тээврийн салбарын чиглэлээр гарах хууль, тогтоомжийн төсөлд санал авахаар нийт 10 эрх зүйн актын төслийг 30-аас дээш хоногийн хугацаатай яамны цахим хуудаст байршуулан ажилласан.<br>2019-04-29 Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр...<br>2019-04-22 Иргэний нисэхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл<br>2019-03-24 Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>2019-02-05 Далай ашиглах тухай хууль /шинэчилсэн найруулга/ төсөл<br>2019-06-14 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн төсөл<br>3 дугаар улиралд санал авах төсөл байршуулаагүй.<br>4 дүгээр улиралд<br>2019-10-17 “Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын төсөл<br>2019-11-29 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журмын төсөл<br>2019-12-09 Иргэний нисэхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл<br>2019-12-16 “Авто замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох журмын шинэчилсэн найруулга” төсөл<br>2019-12-16 “Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журмын шинэчилсэн найруулга” төслүүдэд санал авахаар цахим хуудсанд 30-аас дээш хоног байршуулаад байна. | АЗБХЗГ-100 %<br>АТБХЗГ-100 %<br>АТБХЗХ-100 %<br>**Дундаж үнэлгээ 100 %** |
| 6 | Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;<br>Яамны газар, хэлтэс | **<u>ТЗУГ, БТГ:</u>**<br>“ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” цэсэнд тус яамнаас иргэд, аж ахуй нэгжүүдэд авто зам, автотээвэр, төмөр зам, далайн тээвэр, агаарын тээвэр, салбарын шагнал гэсэн чиглэлээр үзүүлдэг төрийн үйлчилгээнүүдийг авахад шаардлагатай эрх зүйн актууд, бүрдүүлэх баримт бичиг, тэдгээрийг хариуцсан албан тушаалтнуудын мэдээллүүдийг тухай бүр нь шинэчилсэн.<br>Яамны цахим хуудсыг бүрэн шинэчилж мэдээлэл хайх, үзэхэд хялбар, цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгосон.<br>Зам, тээврийн салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт хийсэн ба цахимжуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж програм хангамж хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Тус ажлын гүйцэтгэгчээр “Лидер Вишн” ХХК шалгарч гэрээ байгуулсан ба програмын код хөгжүүлэх ажил хийгдэж байна.<br>**<u>АТБХЗГ:</u>** | ТЗУГ-100 %<br>БТГ-100 %<br>АЗБХЗГ-70 %<br>АТБХЗГ-100 %<br>ТЗДТБХЗГ-70%<br>АТБХЗХ-70 %<br>**Дундаж үнэлгээ 85 %** |

| | | | |
|---|---|---|---|
| | | • АТҮТ ТӨҮГ-тай хамтран ажилласан ба “Техникийн хяналтын мэдээлэл шалгах”, “Автобусны засалбар захиалах”, “Хасагдах тээврийн хэрэгслийн судалгаа”, “Хүчингүй бичиг баримт шалгах” зэрэг үйлчилгээнүүдийг сайжруулж “Зам, тээврийн салбарын цахим үйлчилгээ” цэсэнд дээрх үйлчилгээнүүдийн холбоосуудыг байршуулсан.<br>• Нийслэлийн Мэдээлэл, Технологийн газартай хамтран “Smartcar” системд тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулах хүсэлтийг цахимаар илгээх үйлчилгээг нэвтрүүлэн холбоосыг цахим хуудсанд байршуулсан.<br>• Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг цахимаар захиалах үйлчилгээг нэвтрүүлж холбоосыг цахим хуудсанд байршуулсан.<br>• Замын хөдөлгөөний байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө(2019-2023)-г цахим хуудсанд 2019.12.12-нд байршуулсан.<br>**<u>АЗБХЗГ:</u>**<br>“Авто замын норм, нормативын сан”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Зам, тээврийн салбарын тусгай зөвшөөрлийг цахим болгоход шаардлагатай хөрөнгийг тусгаж, ажлын даалгаврыг боловсруулан, Зөвлөх байгууллагыг сонгон шалгаруулах тендерийг зарлаж 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Лидер вишн групп ХХК-тай гэрээ байгуулсан. Эхний шатны тайланг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдөр захиалагчид ирүүлнэ.<br>**<u>БТГ:</u>**<br>Улсын төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцын талаарх мэдээллийг Сангийн сайдын 196 дугаар журам болон шилэн дансны тухай хуулийн дагуу сар бүр төслийн нэгжүүд шилэн дансны вэб сайтад байршуулсан. Үүнд:<br>• Концессыг гэрээгээр нийт 19 төсөл хэрэгжиж байгаагаас авто замын 16, төмөр замын 1, агаарын тээврийн 2 төсөл.<br>• Улсын төсвийн хөрөнгөөр нийт 28 төсөл хэрэгжиж байгаагаас авто замын 18, автотээврийн 1, агаарын тээврийн 9 төсөл.<br>• Гадаадын зээл тусламжаар нийт 8 төсөл хэрэгжиж байгаагаас авто замын 4, автотээврийн 2, төмөр замын 1, агаарын тээврийн 1 төсөл хэрэгжиж байна.<br>Япон Улсын “ЖАЙКА” байгууллагын техникийн туслалцааны шугамаар хэрэгжүүлж буй “Монгол орны зам, цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхыг сайжруулах төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны 2 дахь хурал 2019 оны 7-р сарын 8-нд зохион байгуулсан. Уг хурлын талаарх мэдээллийг яамны вэб сайтын мэдээний цэс (<u>http://mrtd.gov.mn/i/2063</u>)-нд байрлуулсан<br><br>**<u>ТЗДТБХЗГ:</u>**<br>“Зам тээврийн салбарын цахим үйлчилгээ” цэсэнд “УБТЗ” ХНН-ийн цахим тасалбар авах холбоос холбогдсон. Мөн “Галт тэрэний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газраас Төмөр замын тээврийн салбартай холбоотой статистик болон үндсэн мэдээллийг сар бүр байршуулан ажиллаж байна. ДТ-тэй холбоотой - ?<br>**<u>АТБХЗХ:</u>**<br>• Яамны цахим хуудасны Төрийн үйлчилгээ булан-Салбарын цахим үйлчилгээ цэсэнд МИАТ ТӨХК-ны нислэг захиалга, нислэгийн хуваарийн холбоос холбогдсон.<br>• Иргэний нисэхийн салбарт 2019-2021 онд хэрэгжих Хамтын хэлэлцээрийг яамны вэб хуудсанд байршуулсан. | |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;<br>Холбогдох газар, хэлтэс | **<u>ТЗУГ:</u>**<br>Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-ын танилцуулга, үйл ажиллагааны төрөл, чиг үүргийн талаар цахим хуудасны Үйл ажиллагааны ил тод байдал хэсгийн “Хамтран ажилладаг төрийн бус байгууллага буланд” байршуулсан.<br>**<u>АТБХЗГ:</u>**<br>Автотээврийн хэрэгслийн бүртгэгч нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг 2012.12.12-нд байршуулсан.<br><br>**<u>АЗБХЗГ:</u>**<br>Төрөөс үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх зорилгоор ЗТХ-ын сайдын бүрэн эрхэд хамаарах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны зарим хэсгийн ЗТХ-ын сайдын 2018 оны 169 дүгээр тогтоолоор “Монголын авто замчдын холбоо” ТББ-д шилжүүлсэн тул тус холбооны тухай танилцуулга, үйл ажиллагааны чиглэлийг “Төрийн үйлчилгээ” цэсд байршуулсан. 2019 оны 4 дүгээр улирал Авто замчдын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Авто замчдын холбоотой байгуулсан Нийгмийн түншлэлийн 3 талт хэлэлцээрийг байршуулсан.<br><br>**<u>АТБХЗХ:</u>**<br>Төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд мэдээлэл тавих ёстой. Тус хэлтсийн зүгээс одоогоор үйл ажиллагааны тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа тохиолдол байхгүй тул биелэлт гаргах боломжгүй юм.<br><br>**<u>ТЗДТБХЗГ</u>**<br>“Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай байгуулсан Санамж бичгийг “Хамтын ажиллагаа” буланд ТЗУГ-аас мэдээлсэн. | ТЗУГ-100 %<br>АЗБХЗГ-100 %<br>АТБХЗГ-100 %<br>ТЗДТБХЗГ-100%<br>**Дундаж үнэлгээ 100 %** |
| 8 | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;<br>Холбогдох газар, хэлтэс | Төрийн үйлчилгээ буланд тус яамнаас олгодог тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг **“Төрийн үйлчилгээ”** цэсэнд шинэчилсэн байдал:<br><br>**<u>“Авто зам”</u>** хэсэгт:<br>• Авто замын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг 2019 оны 12-р сарын байдлаар шинэчлэн байршуулсан.<br><br>**<u>“Авто тээвэр”</u>** хэсэгт:<br>• Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтыг 2019-12-09-ны өдөр тус тус шинэчлэн яамны цахим хуудсанд байршуулсан.<br><br>**<u>“Төмөр зам, далайн тээвэр”</u>** хэсэгт:<br>Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект үйл ажиллагааны гэрчилгээ шинээр олгосон, сунгасан, хүчингүй болгосон хуулийн этгээдүүдийн бүртгэлийг 2019 оны 1 дүгээр улирал 6, 2 дугаар улирал 14, 3 дугаар улирал 5, 4 дүгээр улирал 5 мэдээлэл шинэчилж байршуулсан.<br>• 2019 оны жилийн эцсийн байдлаар 33 хуулийн этгээдэд 34 Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгосон. Нийт 67 хуулийн этгээд 80 төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. | АЗБХЗГ-100<br>АТБХЗГ-100 %<br>ТЗДТБХЗГ-100%<br>АТБХЗХ-100 %<br>**Дундаж үнэлгээ 100 %** |

| | | | |
|---|---|---|---|
| | | • 2019 оны байдлаар гэрчилгээ хүссэн болон гэрчилгээний талаар лавлагаа хүссэн нийт 286 хүсэлт ирснээс 107 хүсэлт бүхий баримт бичгийн бүрдлийг гэрчилгээ олгох журмын шаардлага хангаагүй шалтгаанаар буцааж, 164 хүсэлтийг шийдвэрлэн, үлдсэн 15 хүсэлт шийдвэрлэгдэх шатандаа явж байгаа болно. Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар 2019 оны IV улирлын байдлаар дагнасан хэрэглээний салбар замд 112, зүтгүүрт 9, вагонд 296, төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаанд 60, нийт 745 төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой 3-5 жилийн хугацаатай гэрчилгээг 143 хуулийн этгээдэд олгож, 14 гэрчилгээг хүчингүй болгон ажиллаж байна.<br><br>2019 оны 3 дугаар улирлын байдлаар 4 иргэнд Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. 4 дүгээр улиралд хүсэлт ирүүлээгүй болно.<br><br>**<u>“Агаарын тээвэр”</u>** хэсэгт:<br>ТЕЗ-ын эрхлэх асуудлын хүрээнд хийгдсэн дараах ажлуудыг яамны цахим хуудсанд байршуулсан. **Үүнд:** "МИАТ" ТӨХК-ийг ЗТХСайдын 2019.01.22-ны өдрийн 17 дугаар тушаалаар Улаанбаатар-Шанхай-Улаанбаатар чиглэлд, 2019.02.01-ний өдрийн 27 дугаар тушаалаар "МИАТ" ТӨХК-ийг Улаанбаатар-Гуанжоу-Улаанбаатар чиглэлд, 2019.03.12-ны 72 дугаар тушаалаар “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Хонг Конг-Улаанбаатар нислэгийн чиглэлд, 2019.03.15-ны 85 дугаар тушаалаар Хүннү Эйр” ХХК-ийг Улаанбаатар-Бээжин (Daxing airport)-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр тус тус томилсон зэрэг болно.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 248 дугаар тушаалаар агаарын тээврийн “Аэромонголиа” ХХК-ийг Улаанбаатар-Фукуока-Улаанбаатар, Улаанбаатар-Токио-Улаанбаатар, Улаанбаатар-Осака-Улаанбаатар нислэгийн чиглэлд тус тус нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр, 249 дүгээр тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Екатеринбург-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр, 250 дугаар тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Истанбул-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр, 251 дүгээр тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Макао-Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр, 252 дугаар тушаалаар Агаарын тээврийн “Хүннү Эйр” ХХК-ийг Улаанбаатар-Алма-Ата- Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр тус тус томилсон.<br>Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Нислэгийн шугамыг хуваарилах, ачааны агаарын тээвэрлэгчийг томилох тухай” 338 дугаар тушаалаар Алматы, Астана чиглэлийн олон улсын нислэгийн шугамыг “Монголиан Эйрвэйс карго” ХХК-д хуваарилж, ачаа тээврийн нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр, 339 дугаар тушаалаар Шанхай, Гуанжоу, Тяньжин, Эрээн чиглэлийн олон улсын нислэгийн шугамыг “Монголиан Эйрвэйс карго” ХХК-д хуваарилж, ачаа тээврийн нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилсон.<br>Дээрх мэдээллийг ТЗУГ-т өгч, яамны 2019 оны 07, 11 дүгээр сарын тайлангийн Агаарын тээвэр хэсэгт оруулсан. /Дээрх тушаалуудыг нийтэд үзүүлэх боломжгүй тул яамны вэб хуудсанд байршуулах боломжгүй байна./ | |
| 9 | Салбарын хэмжээнд улсын төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, | **<u>“ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР”</u>** булангийн ***“Гадаадын зээлийн төслүүд”*** хэсэгт:<br><br>**<u>ТЗДТБХЗГ</u>**<br>• Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төслийн хэрэгжилтийн явцын танилцуулгыг 2019.12.13-ны өдөр шинэчилсэн. | БТГ-100 %<br>АЗБХЗГ-100 %<br>АТБХЗГ-100 %<br>ТЗДТБХЗГ-100% |

| | | | |
|---|---|---|---|
| | хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;<br>БТГ, ТЗДТБХЗГ, АТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗХ | ***“Гадаадын тусламжийн төслүүд”*** хэсэгт:<br><br>**<u>ТЗДТБХЗ</u>**Г<br>• “Богдхан уулыг тойрох төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр – 01 Трассын судалгаа” төслийн явцын танилцуулга, мэдээллийг 2019.12.13-ны өдөр шинэчилсэн.<br><br>**<u>АЗБХЗГ</u>**<br>• БНХАУ-н Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн хурдны авто зам төсөл”, “Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замын төсөл”, “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам төсөл”, “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам төсөл”, “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам төсөл”-үүдийн мэдээлэл, товч танилцуулгуудыг 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар шинэчлэн байршуулсан.<br>• АХБ-ны зээлээр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд баригдаж буй “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил”-ийн мэдээлэл, танилцуулыг 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар шинэчлэн байршуулсан.<br>• АХБ-ны зээлэээр хэрэгжиж буй “Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн мэдээлэл, таницлуулгыг 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар шинэчлэн байршуулсан.<br>**<u>АТБХЗХ</u>**<br>• Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Нислэгийн шугамыг хуваарилах, ачааны агаарын тээвэрлэгчийг томилох тухай” 338 дугаар тушаалаар Алматы, Астана чиглэлийн олон улсын нислэгийн шугамыг “Монголиан Эйрвэйс карго” ХХК-д хуваарилж, ачаа тээврийн нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр, 339 дугаар тушаалаар Шанхай, Гуанжоу, Тяньжин, Эрээн чиглэлийн олон улсын нислэгийн шугамыг “Монголиан Эйрвэйс карго” ХХК-д хуваарилж, ачаа тээврийн нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилсон. Дээрх мэдээллийг ТЗУГ-т өгч, яамны 2019 оны 07, 11 дүгээр сарын тайлангийн Агаарын тээвэр хэсэгт оруулсан. /Дээрх тушаалуудыг нийтэд үзүүлэх боломжгүй тул яамны вэб хуудсанд байршуулах боломжгүй байна./<br>**“Гадаадын тусламжийн төслүүд”** хэсэгт:<br><br>**<u>АТБХЗГ</u>**<br>• “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн тухай мэдээллийг 2019.09.09-ний өдөр байршуулсан.<br>• Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Зам, тээврийн салбарын нэгдсэн мэдээллийн төв байгуулах” талаар хамтран ажиллах дөрвөн талт санамж бичигт гарын үсэг зурсан тухай мэдээллийг 2019.12.12-нд байршуулсан.<br><br>**<u>ТЗДТБХЗ</u>**Г<br>• “Богдхан уулыг тойрох төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр – 01 Трассын судалгаа” төслийн явцын танилцуулга, мэдээллийг 2019.12.13-ны өдөр шинэчилсэн. | АТБХЗХ-100 %<br>ХШҮДАГ-100 %<br>**Дундаж үнэлгээ 100 %** |

| | | | |
|---|---|---|---|
| | | **<u>БТГ</u>:**<br>• **“Улсын төсвийн төслүүд”** хэсэгт Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын улсын төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн 2019 оны 1-11 дүгээр сарын мэдээг байршуулсан.<br><br>**<u>ХШҮДАГ</u>:**<br>• **“Төслийн тайлан мэдээ”** хэсэгт Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа гадаад зээл, тусламжийн төслүүдийн үйл ажиллагаанд 2018 оны жилийн эцсийн болон 2019 оны нэгдүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг байршуулсан. Төсөл, хөтөлбөрийн мэдээллийг шинэчлэх явцад тогтмол хяналт тавьж, заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна. | |
| | **А хэсгийн дундаж үнэлгээ** | | **96.7** |
| | **Б. Хүний нөөцийн ил тод байдал** | | |
| 1 | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;<br>ТЗУГ | Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан өнөөдрийн байдлаар холбогдох журмууд бүрэн батлагдаагүй байгаа учраас сул орон тоо нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлийн зүгээс түр зогсоох талаар мэдэгдсэн.<br>Яамны нийт албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулахаар 2019 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 06/4395 тоот бичгээр хүргүүлсэн.<br>Тус яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт өөрчлөлт орж байгаатай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг батлах ажлыг түр хугацаагаар зогсоосон.<br>Сул орон тоо нөхөх захиалгыг албан ёсоор Төрийн албаны зөвлөлд хүргүүлсний дараа яамны цахим хуудсанд сул орон тооны мэдээллийг байршуулах чиглэл өгсөн.<br>Тус яамны хэмжээнд нийт 21 орон тоо сул байгаа бөгөөд одоогоор түр орлон гүйцэтгэгч нарыг томилон ажиллуулж байгаа болно.<br>Тус яамны хэмжээнд гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн сул орон тооны мэдээллийг тухай бүр оруулж ажилласан.<br>Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төслийн нэгжийн ажилтан, албан хаагчдыг сонгон шалгаруулалтын мэдээллийг 2019.08.06, 2019.08.15, 2019.09.12-ны өдрүүдэд оруулж ажилласан.<br>Мэдээллийн самбарт тус яамны сул орон тооны мэдээллийг байршуулсан. | 70 |
| 2 | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;<br>ТЗУГ | Яамны цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” буланд “Албан хаагчдын ёс зүй” гэсэн дэд цэсэнд дараах мэдээллүүдийг шинэчлэн байршуулсан: **Үүнд:**<br>- Монгол Улсын төрийн албан хаагчдын Эрхэмлэх есөн зүйл,<br>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33-р тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” /яамны мэдээллийн самбарт байршуулсан/<br>- Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;<br>ТЗУГ | **<u>ТЗУГ</u>**<br>Хүний нөөцийн ил тод байдал буланд “Хүний нөөцийн стратеги” дэд цэсийг ажилуулж, Төрийн албаны хүний нөөцийн стратегийг тодорхойлсон “Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийг цахим хуудсанд байршуулсан. Төрийн албаны тухай хуулийн 33.6-д заасны дагуу тус яамнаас “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг, мөн эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг байршуулсан. | 100 |
| 4 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгжийн болон холбогдох асуудлыг хариуцсан албан хаагчийн үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байгаа ба энэ нь хүний нөөцтэй холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудас, дотоод удирдлагын системийг ашиглан нээлттэй мэдээлж байгууллагын гаднах болон дотоод хэрэглэгчдэд хүргэх, хүний нөөцтэй холбоотой иргэдийн хүссэн мэдээллийг биечлэн болон албан бичиг, утсаар өгөх зэрэг арга хэлбэрээр хэрэгжиж байна. Хүний нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг тодорхойлох, үнэлгээ дүгнэлт өгөхөд албан хаагчдын оролцоог хангах үүднээс яамны дотоод удирдлагын ABLE програмын Санал асуулгын булан болон судалгааны бусад програмыг ашиглан албан хаагчдаас асуулга, судалгаа авч, үнэлгээ дүгнэлт өгч ажиллаж байна. Тухайлбал, Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг хангасан байдалд үнэлгээ өгөх зорилгоор санал асуулгыг 2019 оны 12 дугаар сард явуулсан ба судалгаанд оролцогчдын 68% нь сэтгэл ханамж өндөр, 32% нь дунд үнэлгээ өгсөн байна. | 100 |
| 5 | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх; | Яамны төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 38 дугаар тогтоолоор баталсан “Журам батлах тухай /Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх/“, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын дагуу улирал бүр үнэлж байна.<br>Мөн төрийн албан хаагчдын цалингийн шатлалыг тогтоох асуудлыг албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаатай уялдуулж, тодорхой хугацааны шалгуурыг үндэслэх нь зүйтэй гэж үзэж, ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017.03.29-ний өдрийн 85 дугаар тушаал, 2018 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 272 дугаар тушаалаар тус тус Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт оруулсан бөгөөд яамны цахим хуудаст байршуулав.<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн Төрийн албан хаагчид улирал бүр мөнгөн урамшуулал олгох журам батлагдсан. Энэхүү журмаар төсвийн шууд захирагч энэ журамд нийцүүлэн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох нарийвчилсан журмыг баталж болно гэж заасан. | 100 |
| | **Б хэсгийн дундаж үнэлгээ %** | | **94.0** |
| | **Ил тод байдлын үнэлгээ %** | | **95.7** |

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**
АВТО ЗАМЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР,
ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ГАНТӨМӨР